



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 02 сарын 02 өдөр

Дугаар 4/25

Улаанбаатар хот

Бодлогын чиглэл батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, тус газрын Даргын зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. “Төрөөс нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэл”-ийг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Засгийн газрын тогтоол гарахтай холбогдох бэлтгэл ажлыг ханган ажиллах, холбогдох төрийн, төрийн өмчийн болоод олон нийтийн байгууллагуудад танилцуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Мэдээллийн технологийн бодлого, зохицуулалтын хэлтэс /Б. Билэгдэмбэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЧИНБАТ



0000381



Боловруулсан: *С. Баттулга*
Нийлсэн:
Хуви:
2019 он *02* сар *02* өдөр

ХХМТГ-ын даргын 2019 оны ... сарын ...-ний өдрийн
... тоот тушаалын хавсралт



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗАР**

**ТӨРӨӨС НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙН ТАЛААР
БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЧИГЛЭЛ**

2019 он

Улаанбаатар хот

АГУУЛГА

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ	3
НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	8
ХОЁР. УДИРТГАЛ	9
ГУРАВ. ХАМРАХ ХҮРЭЭ БОЛОН ХЭРЭГЛЭЭ	11
ДӨРӨВ. БОДЛОГЫН ЧИГЛЭЛИЙН НӨХЦӨЛ ШААРДЛАГУУД	12
4.1. Нээлттэй өгөгдлийн удирдлага	12
4.2. Нээлттэй өгөгдлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах	13
4.3. Нээлттэй өгөгдлийг цахим орчинд нийтлэх	13
4.4. Нээлттэй өгөгдлийн форматууд	14
4.5. Олон нийтийн хандлагыг тандах	15
4.6. Тогтсон хуваарь, шийдлийн дагуу нийтлэх мэдээлэл	16
4.7. Нэмэлт шаардлагууд	17
4.8. Хэрэгжүүлэх арга замууд болон хэрэгжилтийг хянан нягтлах	17
<i>Хавсралт 1. Нээлттэй өгөгдөл</i>	<i>19</i>
<i>Хавсралт 2. Гүйцэтгэх үүрэг болон хүлээх хариуцлага</i>	<i>23</i>
<i>Хавсралт 3. 2013 онд Их 8 улсын Нээлттэй өгөгдлийн талаарх зөвлөмж бүлэгт дурдсан зайлшгүй ил тод болгох шаардлагатай нээлттэй өгөгдлийн категори</i>	<i>25</i>
<i>Хавсралт 4. Өгөгдлийн форматууд</i>	<i>27</i>
<i>Хавсралт 5. Эшлэл</i>	<i>30</i>

НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Өгөгдөл	Бүх төрлийн бүтэц бүрэлдэхүүнтэй мэдээллийг
Бүрдэл өгөгдөл	Тодорхой бүтэцтэй болон бүтэцгүй мөн ангилал хийгдэж болохуйц өгөгдөл
Үл тодорхойлох өгөгдөл	Тодорхой нэгэн хувь хүнийг илэрхийлэх өгөгдлөөс хувь хүнийг тодорхойлох, танихад хэрэглэгдэх өгөгдлүүдийг тусгаарласнаар тухайн этгээдийг танин тодорхойлох бололцоогүй болгосон өгөгдөл
Төрийн өгөгдөл	Төрийн байгууллагын цуглуулсан, үүсгэн бий болгосон болон хянан шинжилсэн өгөгдөл
Мета өгөгдөл	Хэсэгчилсэн өгөгдөл болон бүлэг өгөгдлийн нэг болоод түүнээс дээш тооны хэв шинжийг агуулсан мэдээлэл
Нээлттэй өгөгдөл	Нээлттэй, чөлөөтэй хандах бололцоотой дахин ашиглагдах болоод түгээн дамжуулж болохуйц аливаа хувийн мэдээлэл агуулаагүй өгөгдөл болон мэдээлэл түүнчлэн машинд уншигдахуйц форматтай байхаас гадна үнэ төлбөргүй байна
Хүсэлт гаргагч	Нээлттэй өгөгдлийн сан дахь бүлэг өгөгдлүүдэд хандалт хийж буй хувь хүн, аж ахуйн нэгжийг
Зохиогчийн эрх	Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулинд тодорхойлсон утга. Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хууль (2006.01.19).
Мэдээлэл, харилцаа холбооны бодлогын зөвлөл	Монгол Улсын мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөгжил, цахим засаглал хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд удирдлагын түвшинд дэмжлэг үзүүлэх, манлайлах үүрэг бүхий Засгийн газрын харьяа байгууллагуудын удирдлагын түвшинд байгуулагдсан байнгын